

МОНГОЛ-ГЕРМАНЫ ХАМТАРСАН АШИГТ МАЛТМАЛ, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 18.1, 18.7 дүгээр зүйл, Боловсролын сайдын 2026 оны 02 сарын 06-ны А/34 тоот тушаалын хавсралт “Оюутан элсүүлэх журам”, Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС)-ийн дүрэм болон тус “Элсэлтийн журам”-ыг баталсан сургуулийн Ректорын тушаалыг үндэслэл болгоно.

1. Үндэслэл

- 1.1. Энэхүү “Оюутан элсүүлэх журам” (цаашид "Журам" гэх) нь Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС)-ийн Инженерийн бэлтгэл хөтөлбөр, Бакалавр болон Магистрын сургалтын хөтөлбөрийн элсэлтийн үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2. Тус сургууль нь Инженерийн бэлтгэл хөтөлбөр (ИБХ), Бакалавр болон Магистрын хөтөлбөрт элсэлт авна.

2. Элсэлтийн комисс

МГТИС-ийн Ректор нь Монгол Улсын холбогдох хууль, дүрэм журамд нийцүүлэн элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах Элсэлтийн комиссыг томилно.

2.1. Элсэлтийн комиссын гишүүний эрх, үүрэг:

- 2.1.1. Элсэлтийн комиссын гишүүн бүр санал өгөх тэгш эрхтэй бөгөөд санал тэнцсэн тохиолдолд Комиссын дарга санал хураалтыг шийдвэрлэнэ.
- 2.1.2. Элсэгчдийн мэдлэг, ур чадварыг үнэн зөв, бодитой, шударгаар үнэлэх ба МГТИС-ийн үнэт зүйлд нийцүүлэн оюутан элсүүлэх шийдвэрийн ил тод байдлыг ханган ажиллана.
- 2.1.3. Элсэлттэй холбоотой бүхий л гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэнэ.
- 2.1.4. Элсэгчдийн ирүүлсэн баримт бичиг, ярилцлагын үр дүнд үндэслэн элсэгчдийг сонгон шалгаруулж, Захирлын зөвлөлөөр баталгаажуулахаар танилцуулна.
- 2.1.5. Элсэлтийн хорооны үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг тухайн жилд батлагдсан төсвийн хүрээнд Ректорын тушаалаар батална. Удирдах

зөвлөлийн тогтоолоор батлагдсан элсэлтийн хяналтын тооны биелэлтийн үр дүнд үндэслэн, тухайн жилийн батлагдсан төсөвт нийцүүлэн элсэлтийн хороонд мөнгөн урамшуулал олгож болно.

3. Элсэлтийн шаардлага ба шалгуур

- 3.1 Бакалаврын болон Инженерийн бэлтгэл хөтөлбөрт элсэгчид тавигдах шаардлага.
- 3.1.1. МГТИС нь Элсэлтийн Ерөнхий Шалгалт (ЭЕШ)-ын оноо болон батлагдсан хяналтын тоонд үндэслэн элсэгчдэд хөтөлбөрт элсэх эсэх саналыг хүргүүлнэ.
- 3.1.2. Бакалаврын болон Инженерийн бэлтгэл хөтөлбөрт элсэгчид дараах шаардлагыг хангасан байна.

Хүснэгт 1.

Баримт бичиг / Нөхцөл		ЭЕШ-ын босго оноо	
Ерөнхий шаардлага	Бүрэн дунд боловсрол эзэмшсэн байх		
Хөтөлбөр	Бакалавр	Шалгалт 1: Математик, Физик Хими (аль нэг нь)	550
		Шалгалт 2: Англи хэл	550
	Инженерийн бэлтгэл	Шалгалт 1: Математик	490
		Шалгалт 2: Англи хэл	490

- 3.1.3 Хичээлийн жил эхлэхээс өмнө нийт элсэгчдийн англи хэлний түвшин тогтоох шалгалтыг Хэлний төв хариуцан авах бөгөөд Бакалаврын хөтөлбөрт элсэхэд Англи хэлний B2 түвшин (ахисан дунд), Инженерийн бэлтгэл хөтөлбөрт элсэхэд B1 түвшин (дунд) байх шаардлагатай.
- 3.1.4. Дараах нөхцөлд бүртгүүлэгчийг Англи хэлний шалгалтаас чөлөөлнө:
- Бүрэн дунд боловсролыг Англи хэл дээр эзэмшсэн;
 - Англи хэл дээр Бакалаврын хөтөлбөр эзэмшсэн;
 - Англи хэлний түвшин тогтоох шалгалт болох TOEFL (80 iBT-оос доошгүй), эсвэл IELTS (6.0-оос доошгүй) оноо авсан.
- 3.1.5 Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Сайдын 2024 оны А/143 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”-ын 2.4.3-2.4.6 заалтын шаардлагыг хангасан элсэгчдээс ЭЕШ-ын оноо шаардахгүй.

3.1.6 МГТИС-д суралцах чин хүсэл эрмэлзэл, тууштай байдлыг нь дүгнэн тодорхойлох зорилгоор зарим элсэгчээс ярилцлага авч болно.

3.1.7 МГТИС-д суралцах гадаадын иргэн нь 3.1.2, 3.1.4-т дурдсан Англи хэлний шаардлагыг хангасан байхаас гадна тухайн улсын элсэлтийн шалгалттай дүйцэх шалгалтын оноог Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагаар дүйцүүлэн тооцуулсан байна.

3.2 Магистрын хөтөлбөрт элсэгчид тавигдах шаардлага.

3.2.1 Магистрын хөтөлбөрт элсэгчид дараах шаардлагыг хангасан байна.

Хүснэгт 2.

	Баримт бичиг / Нөхцөл
Ерөнхий шаардлага	Инженерчлэл болон Байгалийн ухааны чиглэлийн 180-аас доошгүй Европын Кредит Шилжүүлгийн Систем (ECTS) кредиттэй дүйцэх бакалаврын зэрэгтэй байх
Англи хэл (аль нэгийг хангах)	<ul style="list-style-type: none"> • МГТИС-ийн Англи хэлний түвшин тогтоох шалгалтын үнэлгээ C1 түвшин (ахисан); • Англи хэлээр бакалавраа эзэмшсэн; • TOEFL (80 iBT-оос доошгүй), эсвэл IELTS (7.0-оос доошгүй)

3.2.2 Элсэлтийн комиссын хуралд инженерийн мэргэжлийн профессоруудыг урьж, тухайн элсэгчийн бакалавр зэрэг, судалсан хичээлтэй холбоотойгоор нэмэлт судлах хичээлийн шийдвэрийг гаргаж болно.

3.3 МГТИС-ийн бүх түвшний хөтөлбөрт элсэгчдийн өргөдөл хүлээн авах хугацаа:

Хүснэгт 3.

Элсэгч	Хугацаа
Дотоодын элсэгч	МГТИС-ийн веб сайтад байршуулсан хугацааны дагуу.
Гадаадын элсэгч	04-р сарын 30-ны өдрийн дотор бичиг баримтаа ирүүлнэ.
Шилжин суралцагч	Хугацаа
Хаврын семестрт суралцах	11-р сарын 31-ний өдөр хүртэл

Элсэгч	Хугацаа
хүсэлт гаргах	
Намрын семестрт суралцах хүсэлт гаргах	05-р сарын 31-ны өдөр хүртэл

- 3.4 Элсэгч нь www.gmit.edu.mn цахим хуудсанд бүртгүүлж, шаардлагатай бичиг баримтыг илгээнэ. Элсэгчид илгээсэн мэдээллийн үнэн зөв болохыг өөрөө хариуцна. Аливаа хуурамч мэдээлэл нь МГТИС-д бүртгүүлсэн тухайн элсэлтийг хүчингүй болгох нөхцөл болно.
- 3.5 Элсэлтийн шаардлагыг хангасан элсэгчдэд МГТИС-иас суралцах эрх олгосон тухай мэдээлэл хүргүүлнэ.

1. Оюутан элсүүлэх

- 4.1 Бакалавр болон Инженерийн бэлтгэл хөтөлбөрт оюутан элсүүлэх үйл ажиллагааг ЭЕШ дууссан өдрөөс эхлэн ажлын 10 өдөрт багтаан зохион байгуулна.
- 4.2 Шаардлага хангасан элсэгчдэд элсэх эрхийг олгох бөгөөд элсэгч нь МГТИС-д хүсэлтээ баталгаажуулан дараах бичиг баримтыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

4.2.1 Бакалавр болон Инженерийн бэлтгэл хөтөлбөрт

- Бүрэн дунд боловсролын гэрчилгээний эх хувь. Гадаад, эсвэл Монгол дахь олон улсын сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшсэн бол үнэмлэх, гэрчилгээг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажуулсан байна;
- ЭЕШ-ын онооны батламж хуудас;
- Англи хэлний түвшнийг тодорхойлох баримт бичиг (энэ журмын 3.1.4-д заасан);
- Иргэний үнэмлэхийн лавлагаа;
- Сүүлийн гурван сарын дотор авхуулсан цээж зураг 2 хувь;
- Бусад шаардлагатай бичиг баримт;

4.2.2 Магистрын хөтөлбөрт

- Бакалаврын зэргийн диплом болон дүнгийн хуудасны хуулбар хувь;
- Элсэхийг хүссэн өргөдөл (англи хэл дээр);
- Товч танилцуулга буюу CV (англи хэл дээр);

- Англи хэлний түвшнийг тодорхойлох баримт бичиг (энэ журмын 3.2.1-д заасан);
- Иргэний үнэмлэхийн лавлагаа;
- Сүүлийн гурван сарын дотор авхуулсан цээж зураг 2 хувь;
- Бусад шаардлагатай бичиг баримт.

4.2.3 Гадаадын иргэн

- Монгол улсын боловсролын системтэй дүйцэх өмнөх шатны боловсролын гэрчилгээ, диплом, дүнгийн хуулбарын баталгаат орчуулга;
- Элсэхийг хүссэн өргөдөл (англи хэл дээр);
- Товч танилцуулга буюу CV (англи хэл дээр);
- Англи хэлний түвшнийг тодорхойлох баримт бичиг (энэ журмын 3.2.1-д заасан);
- Гадаад паспортын хуулбар;
- Сүүлийн гурван сарын дотор авхуулсан цээж зураг 2 хувь;
- Бусад шаардлагатай бичиг баримт.

4.3 Элсэх хүсэлт болон холбогдох баримт бичгийг бүрдүүлэн өгөх сүүлийн хугацааг Элсэн суралцах эрх олгосон тухай мэдээлэлд (email) дурдсан байна.

4.4 Бусад их, дээд сургуулиас шилжин суралцах тохиолдолд сүүлийн байдлаар авсан дүнгийн тодорхойлолт, элсэн орсон болон гарсан тушаалын “хуулбар үнэн” дардастай хувь, 4.2-т заасан баримт бичгийн хамтаар бүрдүүлж ирүүлнэ.

4.5 Гадаадын аль нэг улсын их, дээд сургуульд суралцаж байгаад МГТИС-н бакалавр, магистрын хөтөлбөрт шилжин суралцах тохиолдолд сурч байсан сургуульд элсэн орсон тушаал, сургуулийн тодорхойлолт, гадаад дүнгийн хуулга, баталгаат орчуулгын хамт бүрдүүлж ирүүлнэ.

4.6 Монгол, Англи хэлнээс бусад хэл дээр бичигдсэн гэрчилгээтэй тохиолдолд баталгаат Англи хэлний орчуулгыг ирүүлнэ.

5. Элсэгчид олгох тэтгэлэг

5.1. Тэтгэлэгтэй холбоотой асуудал ажиллагааг МГТИС-ийн тэтгэлгийн журмаар зохицуулна.

6. Суралцагчийн гэрээ

- 6.1 Бакалавр болон Инженерийн бэлтгэл хөтөлбөрт элсэх болзол хангасан элсэгчидтэй Сургалт, оюутны асуудал хариуцсан алба гэрээ байгуулах, Магистрын хөтөлбөрт элсэх болзол хангасан элсэгчидтэй Ахисан түвшний сургалт хариуцсан мэргэжилтэн гэрээ байгуулах ба гэрээнд сургууль болон оюутны эрх, үүрэг, гэрээний тусгай нөхцөлийг тусгасан байна.
- 6.2 Элсэгчид (эсвэл асран хамгаалагчид) суралцах эрх олгосон тухай мэдээлэлд заасан хугацаанд “Суралцагчтай байгуулах гэрээ”-г байгуулна. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр заасан хугацаанд гэрээ байгуулаагүй элсэгчийн элсэх эрхийг хүчингүйд тооцно.
- 6.3 Суралцагч нь гэрээнд гарын үсэг зурснаар МГТИС-ийн оюутан болж, оюутны системд нэвтрэх эрх болон бусад шаардлагатай бичиг баримтыг хүлээн авна.

7. Бусад

- 7.1 Энэхүү “Оюутан элсүүлэх журам” нь 2026 оны 4-р сарын 29-ний өдрийн Ректорын тушаалаар баталгаажсанаар хүчин төгөлдөрт тооцож, дагаж мөрдөнө. Элсэлтийн хорооны өмнөх шийдвэрүүд нь тухайн үед элссэн оюутанд хэвээр үйлчилнэ.
- 7.2 Энэхүү журмаар зохицуулаагүй бусад харилцааг Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/143 дугаар тушаалын Хавсралтаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”-аар зохицуулна.